



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 833

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 120,439,400.00 (нэг зуун хорин сая дөрвөн зуун гучин есөн мянга дөрвөн зуун) төгрөгийн балансын үнэ, 104,715,362.42 (нэг зуун дөрвөн сая долоон зуун арван таван мянга гурван зуун жаран хоёр төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Хил хамгаалах ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хил хамгаалах ерөнхий газрын дарга Ц.Сэргэлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал Л.Баттөр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТЭГИЙН
ДАРГА

А.АРИУНБОЛД

Ц.ТҮВШИНЗАЯА

0000621

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
2019 оны 07 дугаар сарын 22-ны өдөр
338 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГӨЛТЭЙ,
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтанд орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл (төгрөг)
1	Рентген аппарат (newtech)	2007.07.28	ш	1	120,439,400.00	104,715,362.42	15,724,037.58
	Нийт дүн				120,439,400.00 (нэг зуун хорин сая дөрвөн зуун гучин есөн мянга дөрвөн зуун)	104,715,362.42 (нэг зуун дөрвөн сая долоон зуун арван таван мянга гурван зуун жаран хоёр төгрөг дөчин хоёр мөнгө)	15,724,037.58 (арван таван долоон зуун дөрвөн мянга долоон төгрөг найман мөнгө)